



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/846

Булган сум

Агентлаг, байгууллагын дарга нарын
2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг
дүгнэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 52.2, 52.3, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.9, 4.10 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.2 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоол, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг, байгууллагын 2023 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийн үнэлгээг хавсралтаар баталсугай.

2.Төрийн албан хаагчийн Гүйцэтгэлийн үнэлгээгээр “Маш сайн” буюу “Сайн” үнэлгээ авсан холбогдох агентлаг, байгууллага, газрын дарга нарыг Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын дагуу урамшуулахыг төсвийн шууд захирагч, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.

3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэсэн байдалд шинжилгээ хийж, 2024 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг оны эхнээс заалт нэг бүрээр нь хяналтад авч, биелэлтийг хагас, бүтэн жилээр тооцож тайлагнахыг агентлаг, байгууллагын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323011014

Аймгийн Засаг даргын 2023 оны
12 сарын 21-ны өдрийн А/846 тоот
Захирамжийн хавсралт



Аймгийн Засаг даргын дэргэдэх агентлаг,
байгууллагуудын 2023 оны Гүйцэтгэлийн
төлөвлөгөөний хэрэгжилтийн үнэлгээ

Д/д	Агентлаг, байгууллагуудын нэр	Үнэлгээ хувиар
1	Онцгой байдлын газар	96.2
2	Цагдаагийн газар	95
3	Шүүхийн шинжилгээний хэлтэс	90
4	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	91.6
5	Улсын бүртгэлийн хэлтэс	93.3
6	Санхүүгийн хяналт дотоод аудитын алба	95
7	Татварын хэлтэс	98.7
8	Орон нутгийн өмчийн газар	97.1
9	Боловсрол шинжлэх ухааны газар	94
10	Эрүүл мэндийн газар	87.2
11	Хөдөлмөр халамж үйлчилгээний газар	95
12	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	94
13	Нийгмийн даатгалын хэлтэс	97.5
14	Биеийн тамир, спортын газар	92.3
15	Хүнс хөдөө аж ахуйн газар	94
16	Байгаль орчин, аялал жуулчлалын газар	91
17	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар	91
18	Мал эмнэлгийн газар	86
19	Статистикийн хэлтэс	93.6

20	Стандартчилал хэмжил зүйн хэлтэс	95.1
21	Ус цаг уур, орчны шинжилгээний төв	93.8
22	Соёл урлагийн газар	94.1
23	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	91
24	Музей	90.5
25	Хөгжимт жүжгийн театр	90
26	Аймгийн Төв номын сан	91.2
27	"Булган мээж" ОНӨХХК	87.8
28	"Хөдөө аж ахуй хөгжлийн ирээдүй" ОНӨХХК	88